

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ,
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

..... /Г.ЭНХМӨНХ/

БАТЛАВ.

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“РЕСУРС ПАРТНЕРС ГРУПП” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

...../Д.ДАЯНДЭМЭД/



РЕСУРС ПАРТНЕРС ГРУПП ХХК

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”- ЫН 2026 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021578

ХЯНАСАН:

БОУАӨЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

...../ /

БОЛОВСРУУЛСАН:

“РЕСУРС ПАРТНЕРС ГРУПП” ХХК-НИЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН:

...../ Д.БУЯНЗУЛ /

2025 он

АГУУЛГА

ОРШИЛ.....	2
НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ	8
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	9
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10
4.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө...	10
4.1.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
4.1.3. Хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
4.1.4. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
4.1.5. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	13
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	14
4.3. Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	15
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
4.6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	16
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18
4.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	20
4.10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	20
4.11. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардал.....	21

ОРШИЛ

“Ресурспартнерс групп” ХХК-ийн Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Хавтгай-III” нэртэй хайлуур жоншны уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖЯ-наас 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд төлөвлөлтийг тус журмын 1 дүгээр хавсралтын “А”-д заасан агуулгаар боловсруулсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан. Уурхайн олборлолтын ажил 2024 оны 12-р сард эхэлсэн ба 2025 он уурхайн олборлолтын нэг дэх жил, 2026 он нь уурхайн олборлолтын хоёр дахь жилээр тооцогдоно. Уурхайн ашиглалтын эхний хоёр жилд уурхайн ашиглалтын хүрээнд гүйцэтгэгдэх техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил уулын ажлын төлөвлөлттэй холбоотой байхгүй байна. Тиймээс нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд сум орон нутгийн удирдлагатай санал солилцон орон нутагт эвдрэлд өртсөн талбайд техникээр гүйцэтгэх нөхөн сэргээлт хийх шаардлагатай газарт ажиллахаар төлөвлөлөө. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд сум орон нутгийн удирдлагаас тавьсан саналын дагуу Батноров сумын нутагт ойжуулалт хийхээр хашаалан бэлтгэсэн талбайд 2026 онд нэмэлт тарилт хийхээр төлөвлөлөө.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 20,639,000 төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөвлөгөөний нэр: “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Ресурспартнерс групп” ХХК

Төслийн зорилго: “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ын хүдрийг олборлож, бутлан ангилан, сайн чанарын жоншыг зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга


№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Ресурспартнерс групп” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9011328128
3	Уурхайн нэр		Хавтгай-III
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Хэнтий
5		Сум/Дүүрэг	Батноров
6	Ашигт малтмалын төрөл		Хүдэр
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-021578
8	Ашиглалт эхэлсэн огноо		2024
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Чингэлтэй
11		Баг/Хороо	6-р хороо
12		Гудамж/Байр	Лааганы гудамж, 63А байр 01 тоот
13		Гар утас	99082810
14	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал Д.Даяндэмэд
15		Гар утас	99082810
16		Электрон шуудан	dalaidayanaa@yahoo.com

Төслийн байршил: “Хавтгай -III” хайлуур жоншны орд нь Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт байрладаг.

- Засаг захиргаа: Хэнтий аймаг, Батноров сум,
- Ордын нэр: "Хавтгай-III хайлуур жоншны орд"
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Хайлуур жонш
- Трапедийн номенклатур: М-4-139
- Талбайн нийт хэмжээ: 633.58 га

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн солбицол

№	Газарзүйн солбицол					
	Уртраг			Өргөрөг		
1	111	27	1.88	48	5	51
2	111	27	1.88	48	6	51.85
3	111	28	31.87	48	6	51.85
4	111	28	31.87	48	7	51.82
5	111	27	1.88	48	7	51.82
6	111	27	1.88	48	7	1.81
7	111	25	41.87	48	7	1.81
8	111	25	41.87	48	6	36.04
9	111	26	7.18	48	6	35.76
10	111	26	7.18	48	5	51



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг

Орд ашиглах тусгай зөвшөөрөл: Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл “Ресурспартнерс групп” ХХК-д 633.58 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-021578 дугаар бүхий гэрчилгээг 2020 оны 04 сарын 21- ний өдөр олгосон байна.

Уурхайн одоогийн байдал: “Ресурспартнер групп” ХХК нь Хавтгай-III хайлуур жоншны ордыг ашиглах ТЭЗҮ-ийг 2024 онд батлуулсан бөгөөд түүнээс хойш үйл ажиллагаа явуулж байна.

Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц:

Ил уурхайн С зэрэглэлийн нөөцөд тулгуурлаж хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг магадалсан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадалсан В' үйлдвэрлэлийн нөөц нь 294.12 мян.тн хүдэр байна. Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр $6.92 \text{ м}^3/\text{м}^3$ буюу $2.55 \text{ м}^3/\text{тн}$ болж байна.

Төслийн хүчин чадал: Төслийн хүчин чадал: 2026 оны төлөвлөгөөгөөр экспортод 49.95 мян.тонн бүхэллэг хайлуур жонш, 149.84 мян.тонн хайлуур жоншны хүдэр гаргана. Уурхай нь жилд 153 хоног ажиллана. Уурхайн үйл ажиллагаа нь хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Тэсэлгээний ажил: Тэсэлгээний ажилд дотоодод үйлдвэрлэж буй энгийн найрлагат “ANFO” найрлагат тэсрэх бодис, мөн эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. Тэсэлгээг **10 хоногт нэг удаа** хийх ба тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу аюулгүй байдлыг дээд зэргээр хангасны үндсэн дээр өрөмдлөг-тэсэлгээний ажлыг мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээлэн гүйцэтгүүлнэ.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ландшафт: “Хавтгай-III хайлуур жоншны орд” нь ландшафтын мужлалаар Онон Улз голын сав газрын хөмбөн-цулдам нам уул, хотгор, суурьт тал бүхий хээр, хуурай хээрийн мужид багтана. Төслийн талбай орчим нь Монгол орны физик газарзүйн мужлалаар газрын гадаргын хувьд Хангай-Хэнтийн уулархаг их мужид харьяалагдана.

Уур амьсгал, агаарын чанар: Бүх талаараа Азийн өндөр уулсаар хүрээлэгдэж далай тэнгисээс ихээхэн алслагдсан, гипсометрийн өндөр байрлалд оршдог тул тэнгисийн чийглэг салхи нэвтрэх боломж тун бага байдаг онцлогтой. Цаг уурын энэ онцлог нь дүүргийг эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирлын болон хоногийн халуун хүйтний хэлбэлзэл, өөрчлөлт ихтэй болгодог.

Өвөлдөө олон жилийн дундаж температур -20°C аас, -35°C хэм хүрч, дулаан нь 7-р сард 25°C аас 30.9°C хүрнэ. Жилд унах хур тундасны дундаж хэмжээ 200-300 мм тунадас унана, Харьцангуй чийглэг уур амьсгалтай ба харьцангуй дундаж чийгшилт 35% байна. Салхины хурд өвөлдөө 1.8-2 м/сек хүртэл салхилдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-30 см орчим байдаг.

Усан орчин: Усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт багтана. Ордын сумаар, Эхэнбүрд, Дундбүрд, Адагбүрд, Бургаст зэрэг байнгын урсгалтай голууд урсан өнгөрдөг.

Ордын сумын талбайд байгаа томоохон амууд, гуу жалга нь баруун, баруун хойш чиглэлтэй юм. Тэдгээрийн ихэнх нь эхэндээ бага зэргийн ундаргатай, булгуудтай, зарим нь түр зуурын урсгалтай жижиг горхиуд байдаг. Цас борооны усаар тэжээгддэг эдгээр горхиуд нь адаг руугаа шургаж тасардаг ба зарим нэг нь Бүхэг, Түргэний голд цутгадаг.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих талбай нь ухаа толгод бүхий нутаг хамрагдах бөгөөд талбайд тархсан хөрсний хувьд зонхилох хэв шинж нь уулын хар хүрэн хөрс, толгод болон нам уулсын хажуугаар чулуурхаг нимгэн хар шороон хөрс.

Ургамлан нөмрөг: Ойт хээрийн ба хээрийн бүсийн өвслөг, цэцэгт ургамал, газар зүйн бүх төрлийг хамаарах бөгөөд хадлан, бэлчээр газар тариалангийн талбайн хувьд дунд зэрэг төлөвтэй.

Амьтан: Тарвага, бор гөрөөс, цагаан зээр, саарал чоно, үнэг, хярс, шилүүс, мануул, дорго, туулай, чандага, өмхий хүрэн, зурам зэрэг ан гөрөөс элбэг байх ба буга, зэрлэг гахай нилээд байдаг байсан ч ховордсон. Хэрлэн мөрөнд соом, булуу цагаан, зэвгэ, цурхай загас байх ба зарим үед тул загас үзэгддэг.

Түүх соёлын дурсгалд газрууд: Үйл ажиллагаа явуулах төслийн талбайд түүх соёлын дурсгалт газрууд илрээгүй.

Хэнтий аймгийн Батноров сумын нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Засаг захиргааны нэгжийн хувьд сум нь Эрдэнэчандмань, Эхэнбүрд, Баян, Баянбулаг, Идэрмэг, Дундбүрд, Бэрх гэсэн 7 багтай.

2023 оны жилийн эцсийн байдлаар Батноров суманд нийт 5689 хүн ам оршин сууж байна. Үүнээс 2913 нь эрэгтэй, 2776 нь эмэгтэй эзэлж байна. Өөрөөр хэлбэл Батноров сумын нийд иргэдийн 48.8% нь эмэгтэй, 51.2% нь эрэгтэй эзлэж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 1773 өрх бүртгэгдсэнээс 466 өрх буюу 61.3%-ийг 1 ам бүлтэй өрх эзлэж байна. Нийт өрхийн 845 нь малчин өрх байна. Мал сүрэг нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 328.7 мянган толгой мал үүнээс Тэмээ 0.2 мян.толгой, Адуу 32.7 мян.толгой, Үхэр 26.8 мян.толгой, Хонь 175.0 мян.толгой, Ямаа 93.9 мян.толгой мал тус тус тоолуулсан байна. (эх сурвалж: “Хэнтий аймгийн статистикийн эмхэтгэл 2023”, 2024 он)

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн төрийн 6 байгууллагатай. Хувийн хэвшлийн 72 аж ахуй нэгж, иргэн арьс шир боловсруулах, хүнсний дэлгүүр, талх гурилан боовны цех, цагаан идээ боловсруулах, гар урлал, үсчин гоо сайхан зэрэг жижиг дунд үйлдвэрлэлүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Томоохон уул уурхай Алтан гадас одонт Бэрхийн уурхай, Ямаатын уурхай, Хавтгайн уурхай, Чимэдийн уурхай, Баяжуулах үйлдвэр гэсэн байгалийн баялаг жонш үйлдвэрлэх, боловсруулах уурхай, үйлдвэрүүдтэй. Эдийн засгийн чадамжийн хувьд Бэрхээс тусдаа төсөвтэй явдаг бөгөөд сумын нийт төсөв нь жилийн 3.2 тэрбум.төгрөг, үүнээс сумын өөрийн татварын орлого 0.2 хувийг нь бүрдүүлэн төвлөрүүлдэг.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл: Ил уурхайн аргаар үйл ажиллагаа явуулах учраас газрын гадаргад өөрчлөлт орно. Хөрс хуулалт, гадаад болон дотоод овоолго, бутлах үйлдвэр, ажилтнуудын түр амьдрах байр зэрэг бүхий л уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлнө.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад суларсан нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх, бутлуурт орж буй чулуулаг дахь тоос агаарт дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл байна.

Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Гадаргын болон газрын доорх усны нөөцөд нөлөөлөх нөлөөлөл бага байна.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдахаар байна.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй.

Эерэг нөлөөллийн хувьд амьтны аймгийн мониторинг нь энэ бүс нутаг орчмын амьтны хотын тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангах чухал ач холбогдолтой.

Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх сөрөг нөлөөлөл: “Ресурспартнерс групп” ХХК–ний ашиглалтын талбайн ойр орчимд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс, түүнтэй холбоотой эд өлгийн зүйлс илрээгүй байна.

Олборлолтын явцад түүх эд өлгийн олдвор олдсон тохиолдолд холбогдох Төрийн байгууллагад мэдэгдэн хамтран ажиллах шаардлагатай.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Улсад болон орон нутагт тодорхой хэмжээний татвар төлөх, орон нутагттай хамтран ажиллах гэрээний тодорхойлсон ажлууд дээр тусламж дэмжлэг үзүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, сум орон нутагт худалдан авалт эдийн засагт тодорхой хэмжээгээр эерэгээр нөлөөлөх нөлөөлөл байна.

Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл: Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:
Хэнтий аймгийн Батноров сумын нутагт Хавтгай-III хайлуур жоншны ордын ашиглалтын үйл ажиллагааны Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ 2024 онд батлагдсан тайлангийн хүрээнд тогтоогдсон төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах үндсэн зорилготой.

2026 онд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр нэн тэргүүнд тавих зорилтот ажлууд нь байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт нийцлийг сайжруулан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлуудын биелэлтийг бүрэн хангаж ажиллах зорилт тавин ажиллана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2026 оны Хавтгай-III ордын ашиглалтын үйл ажиллагааны бүх үе шатыг хамарна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А-618 журмын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-уудыг тус тус баримталснаас гадна байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурласан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 3-1. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд

д/д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	10
2	Нөхөн сэргээлт	1
3	Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	1
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	1
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1
6	Осол эрсдлийн менежмент	2
7	Хог хаягдлын менежмент	7
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3
9	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	4
10	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	3
Нийт		35

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

4.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4-1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ил уурхайн технологийн зам ашиглалтын үед тоосжилт үүсэх, хүдэр баяжуулалтын үед бутлуур шигшүүр ажиллах үед тоосжилт үүсэх	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх (дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Уурхайн технологийн зам, хүдэр шигших бутлах ажлын үед	м ³	0.085	1636,25	139,0	Тоосжилт их байх дулааны улиралд	Монгол улсын Агаарын тухай хууль
				м ²	11,900	1	--*--	Усалгаа хийх шаардлагатай үеүүдэд	MNS4585:2016 Агаарын чанарын стандарт-Техникийн ерөнхий шаардлага
		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах-хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (шаардлагатай бол хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулах)	Уурхайн технологийн зам	км	500.0	--*--	500.0	Шаардлагатай байршлуудад	MNS 6260:2020 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
Нийт мян.төг			639.0						

4.1.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4-2. Гадаргын ба газрын доорхи усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн үйл ажиллагааны хүрээнд газрын доорхи ус ашиглалт үүсэх,	Уурхайн ундны усны хэрэглээг тогтмол бүртгэх, усны төлбөрийг цаг тухай бүрт төлж, байгаль хамгаалагчаар баталгаажуулах	Уурхайн тосгон	м³	1000	Баталгаажуулсан усны тоолуурын заалтаар	1000	Тогтмол	MNS0900:2018 Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” - MNS4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага”
		Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	Уурхайн нийт ажилчид	ш	200.0	1.0	200.0	Шинээр ажилд орж буй бүх ажилчид сургалтад хамрагдах	
2	Ус ашиглахтай холбоотой холбогдох хуулийн нийцлийг хангах	Ус ашиглах дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	--*--	Дотоод зардлаар			Жилд 1 удаа	
Нийт мян.төг			1200,0						

4.1.3. Хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4-3. Хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үржил шимт хөрс хуулагдах ба хадгалах явцад хөрсний үржил шим өөрчлөгдөх, доройтох ШТМ асгарч орчны хөрсөн бүрхэвчийг бохирдуулах Ахуйн хатуу хог хаягдлаар хөрс бохирдох, орчны эрүүл ахуйн байдал алдагдах	Газарзүйн мэдээллийн системд шимт, шимэрхэг хөрсний овоолгын байршил, хэмжээг бүртгэх, зурагжуулах, тухайн овоолгыг газар дээр нь хаягжуулах	Уурхайн үйл ажиллагааны туршид	га/м ³	*	Хөрсний овоолгын хэмжээг зураглах, хэмжилт хийсэн ажлын тайлан	*	Жилийн турш	5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
2		Жилийн турш							
3		ШТМ хөрсөнд алдагдахаас сэргийлэн техникийн засвар үйлчилгээ хийх талбайг хатуу хучилттай болгох		л/м ²	500.0	2.0	1000.0	Жилийн турш	
4		Олон салаа зам гарган авто замаар хөрс эвдрэхээс сэргийлж нэг замын маршрутаар зорчих, нэг замын маршрутыг дотооддоо батлуулж мөрдөж ажиллах, хяналт тавих, гэрээт байгууллагуудад мөрдүүлэх		км	Дотоод журам				
Нийт мян.төг			1000.0						

4.1.4. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн хүрээ хязгаар гадаад овоолго, уурхайн гадаад овоолго зам талбайн хэмжээгээр ургамлан нөмрөг, бэлчээрийн доройтол үүсэх	Ажиллагсдын байрлах суурины эргэн тойронд машин механизмын хөдөлгөөний хязгаарласан гортиг татаж ургамлан нөмрөг талхлагдахаас сэргийлэх	Уурхайн кемпэд	Зам талбайг тодорхой лон зурвас татсан байдал	Дотоод зардлаар			III болон IV улирал	MNS 6140:2010 Техникийн шаардлага, MNS 6254:2011 Мод, сөөгний суулгацыг бойжуулах. Ерөнхий шаардлага
2		Хаврын мод тарилтын хугацаанд кемпд тарьсан модны усалгаа арчилгаа хийх, нэмэлт тарилт хийх	Уурхайн бүс	ш	10,0	100	1000,0		
Нийт мян.төг			1000,0						

4.1.5. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн талбайн ойр орчимд зэрлэг ан амьтдыг бэлчээр нутаг хумигдах, өвөл хаврын улирлын бэлчээр өвс тэжээлийн хомсдол үүсэх	Төслийн талбайн ойр орчимд байрлах ховордсон ан амьтдад биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн ногоон тэжээл, хужир шүү тогтоосон байршлуудад тавих	Ховор зүйлийн амьтдын зам дагуу	*	500.0	2.0	1000.0	Өвөл болон хаврын улиралд	Сум, орон нутгийн байгаль хамгаалагч нартай харилцан зөвшилцөж хамтран ажиллах
2									
Нийт мян.төг									

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 3-2. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Орон нутгаас санал болгосон техникийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай газарт 0.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж ажиллана	Сум орон нутагт	га	4,000	0.5	4,000	II болон III улирал	MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5917 : 2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Нийт мян.төг			4,000						

4.3. Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд сумын төвд ойжуулалтын ажил хийхээр төлөвлөсөн талбайд мод тарилтын ажил хийж гүйцэтгэнэ.	Сум орон нутагт	ш	10,0	200	2,000	II болон III улирал	MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5917 : 2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									Техникийн ерөнхий шаардлага
Нийт мян.төг			2,000						

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 3-3. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговрын асуудал үүсээгүй байна	Санал гомдлын хүрээнд нүүлгэн шилжүүлэлттэй нөхөн олговрын асуудал үүсэх үед шийдвэрлэж ажиллана.	Уурхайн нөлөөллийн бүсд хамрагдсан айл өрхүүд	Төслийн үйл ажиллагааны явцад тогтмол	Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай” журам
Нийт мян.төг			-		

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн талбай орчимд түүх соёлын дурсгалт олдвор илрээгүй.	Уурхайн ухалт ахилтын хүрээнд археологийн палентлогийн олвор илрэх үед холбогдох байгууллага болох ШУА-ийн харьяа Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэх арга хэмжээ авна	Уурхайн бүс	*	Дотоод зардлаар		Жилд 1 удаа	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
Нийт мян.төг			-					

4.6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө**Хүснэгт 3-4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

№	Болзошгүй аюул, осол эрсдэл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гэнэтийн болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, гал түймэр, үер усны, техникийн осол аваараас шалтгаалан тухайн орчинд бохирдол доройтол үүсэх	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Уурхайн ашиглагдаж байгаа техникүүд	4	Үйл ажиллагааны дотоод зардлаар		Тогтмол	Химийн хорт бодис аюултай бодисын тухай хууль
2		Галын аюулгүй байдлын үед ажиллах сургалт мэдээлэл, практик сургалтыг зохион байгуулах		*	Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал		Жилд 1 удаа	Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль
Нийт мян.төг			--*--					

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Уурхайн ойр орчимд гадна орчны цэвэрлэгээг хийх	Уурхайн бүс	удаа	--*--	--*--	--*--	14 хоногт 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
2		Хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулах сургалтыг ажилчдад хүргэж, кемп, амралтын гэрүүдэд ангилан ялгах хогийн сав байршуулах,		ш	2000.0	1.0	2000.0	Тогтмол	
3									
4									
5		Энгийн хог хаягдлыг сумтай гэрээ байгуулан хогийн цэгт тээвэрлэнэ.		Энгийн хог хаягдлыг цуглуулан тээвэрлэсэн тоо давтамж	Дотоод зардлаар			Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
6	Аюултай хог хаягдал	Техникийн ашигласан тос маслыг шаардлага хангасан нөхцөлд түр цуглуулан, мэргэжлийн байгууллагад гэрээний үндсэн дээр нийлүүлэх	Аюултай хог хаягдал цуглуулах талбай	Аюултай хог хаягдал үүсэх бүсд	Гэрээний үндсэн дээр		Үйл ажиллагаа ны явцад		
7					Гэрээний үндсэн дээр				
8					Аюултай хог хаягдлын дагалдах бичиг, бүртгэлийг тогтмол хөтлөх	Дотоод зардлаар			
Нийт мян.төг			2800.0						

4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 3-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа давтамж	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
АГААРЫН ЧАНАР							
1	Агаарын тоосонцорын шинжилгээ, Дуу чимээ, физик бохирдлыг хэмжих SO2, NO2	3	Уурхайн карьер, жонш бутлах, ангилан ялгах хэсэгт, кемп орчим	Жил бүрийн II, IV улиралд, хөндлөнгийн хяналтаар	2500.0		• Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016 • MNS 3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага, • MNS 5061:2001. Нүүрс Хүчлийн хий-CO2 тодорхойлох эзэлхүүний арга, • MNS 0012-1-015:1987. Чимээ шуугиан–Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга, • MNS0017.2.5.11-1998. Азотын давхар исэл
2	Агаарын тоос тоосонцорын мониторинг (TSP, PM10, PM2.5)	3					
УСАН ОРЧИН							
